

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/014/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/182
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ДААРИЙМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Заамар сумын орон нутгийн санхүүжилтээр тус сургуулийн спорт заалны их засварын ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар “Заамар констракшн” ХХК 163,946.0 мянган төгрөгөөр гүйцэтгэж, сурагчид эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, авьяас чадвараа хөгжүүлэх боломжтой болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96.0

4126020169

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хувиар дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 262,745,695.10 | 315,728,793.21 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 193,514,153.72 | 242,679,019.37 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 193,514,153.72 | 242,679,019.37 |
| 3121 | Төгрөг | 193,514,153.72 | 242,679,019.37 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 193,514,153.72 | 242,679,019.37 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 69,231,541.38 | 73,049,773.84 |
| 351 | Түүхий эд материал | 134,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 134,000.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 69,097,541.38 | 73,049,773.84 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 96,500.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 1,325,910.00 | 907,910.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 996,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 66,679,131.38 | 72,141,863.84 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 818,425,842.17 | 943,926,162.48 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 818,425,842.17 | 943,926,162.48 |
| 392 | Биет хөрөнгө | 753,965,842.17 | 879,466,162.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 611,054,479.00 | 775,000,455.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (147,047,663.76) | (172,224,099.48) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 265,264,195.00 | 304,393,625.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (77,949,135.31) | (126,980,489.99) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 174,323,131.38 | 143,508,180.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (98,816,845.33) | (71,266,548.80) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,668,663.67 | 2,668,663.67 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,180,370.58) | (1,283,011.50) |
| 39217 | Ном | 25,649,388.10 | 25,649,388.10 |
| 393 | Биет бус хөрөнгө | 64,460,000.00 | 64,460,000.00 |
| 39301 | Программ хангамж | 902,500.00 | 387,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (902,500.00) | (387,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 64,460,000.00 | 64,460,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,081,171,537.27 | 1,259,654,955.69 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,081,171,537.27 | 1,259,654,956.59 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,081,171,537.27 | 1,259,654,956.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 311,643,563.78 | 311,643,563.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 311,643,563.78 | 311,643,563.78 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 567,456,093.16 | 745,939,512.48 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 567,456,093.16 | 572,956,093.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 172,983,418.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 202,071,880.33 | 202,071,880.33 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,081,171,537.27 | 1,259,654,956.59 |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,829,603,116.80 | 2,161,240,668.56 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 85,556,516.80 | 225,910,168.56 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 85,556,516.80 | 225,910,168.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,995,300.00 | 168,487,726.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,995,300.00 | 4,541,750.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 163,945,976.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 47,150,376.60 | 42,049,582.10 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 36,410,840.20 | 15,372,860.46 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,744,046,600.00 | 1,935,330,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,569,282,800.00 | 1,779,463,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,569,282,800.00 | 1,779,463,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 174,763,800.00 | 155,866,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 174,763,800.00 | 155,866,900.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,702,068,281.88 | 1,988,257,250.14 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,702,068,281.88 | 1,988,257,250.14 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,584,065,858.71 | 1,871,528,195.33 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,133,014,450.70 | 1,356,103,609.07 |
| 210101 | Үндсэн цалин | 744,276,494.21 | 816,606,304.97 |
| 210102 | Нэмэгдэл | 348,265,856.49 | 476,641,194.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 17,390,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,472,100.00 | 45,466,110.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 138,977,605.87 | 161,792,093.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 95,704,137.07 | 109,634,585.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,341,085.14 | 13,514,426.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,754,702.26 | 6,930,839.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,215,478.71 | 6,317,409.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,962,202.69 | 25,394,832.13 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 148,903,676.83 | 150,865,345.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,882,816.83 | 6,844,485.19 |
| 210302 | Түлш, халаалт | 140,350,336.00 | 140,350,336.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,670,524.00 | 3,670,524.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 30,759,628.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 4,714,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 3,038,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 10,019,570.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх зардал | - | 1,076,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 3,039,200.00 |
| 210408 | Бараа материал актгалсны зардал | - | 8,872,458.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 4,000,000.00 |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210702 | Дотоод албан томилолт | - | 4,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,229,670.77 | 28,751,282.14 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,547,700.00 | 3,747,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,681,970.77 | 25,003,882.14 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 142,940,454.54 | 134,256,237.79 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,797,300.00 | 12,056,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,128,900.00 | 9,785,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 88,014,254.54 | 112,414,937.79 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 118,002,423.17 | 116,729,054.81 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 95,142,300.00 | 116,727,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 79,348,500.00 | 116,727,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,793,800.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 22,860,123.17 | 1,554.81 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,860,123.17 | 1,554.81 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 127,534,834.92 | 172,983,418.42 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 5,074,097.00 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,342,697.00 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 3,731,400.00 | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (5,074,097.00) | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 122,460,737.92 | 172,983,418.42 |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,746,041,900.00 | 1,939,872,250.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,995,300.00 | 4,541,750.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,995,300.00 | 4,541,750.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,995,300.00 | 4,541,750.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,995,300.00 | 4,541,750.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,744,046,600.00 | 1,935,330,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,569,282,800.00 | 1,779,463,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,569,282,800.00 | 1,779,463,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 174,763,800.00 | 155,866,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 174,763,800.00 | 155,866,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,670,260,230.34 | 1,858,787,684.35 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,670,260,230.34 | 1,858,787,684.35 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,552,257,807.17 | 1,742,058,629.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,133,166,316.37 | 1,356,103,609.07 |
| 210101 | Үндсэн цалин | 744,528,359.88 | 817,049,869.02 |
| 210102 | Нэмэгдэл | 348,165,856.58 | 476,641,194.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 17,390,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,472,099.91 | 45,022,545.95 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 138,825,740.20 | 161,792,093.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 94,374,752.85 | 109,634,585.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,184,386.94 | 13,514,426.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,744,319.08 | 6,930,839.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,499,976.28 | 6,317,409.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,022,305.05 | 25,394,832.13 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 148,903,676.83 | 150,865,345.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,882,816.83 | 7,016,404.94 |
| 210302 | Түлш, халаалт | 140,350,336.00 | 140,350,336.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,670,524.00 | 3,498,604.25 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 5,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,731,673.77 | 31,449,682.14 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,547,700.00 | 3,747,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 32,183,973.77 | 27,702,282.14 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 94,630,400.00 | 36,847,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,051,500.00 | 27,038,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,578,900.00 | 9,809,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 118,002,423.17 | 116,729,054.81 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 95,142,300.00 | 116,727,500.00 |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|----------------------|------------------------|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 79,348,500.00 | 116,727,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,793,800.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 22,860,123.17 | 1,554.81 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,860,123.17 | 1,554.81 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 75,781,669.66 | 81,084,565.65 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 31,919,700.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 31,919,700.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 31,919,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 31,919,700.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (31,919,700.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 75,781,669.66 | 49,164,865.65 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 117,732,484.06 | 193,514,153.72 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 193,514,153.72 | 242,679,019.37 |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|--|------------------------------|--------------------------|---|
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 311,663,563.78 | 202,641,240.69 | 154,049,030.38 | 668,353,834.85 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 311,663,563.78 | 202,641,240.69 | 154,049,030.38 | 668,353,834.85 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | (20,000.00) | - | 25,764,554.97 | 25,744,554.97 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 311,643,563.78 | 202,071,880.33 | 567,456,093.16 | 1,081,171,537.27 |
| 2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 311,643,563.78 | 202,071,880.33 | 567,456,093.16 | 1,081,171,537.27 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 5,500,000.00 | 5,500,000.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 311,643,563.78 | 202,071,880.33 | 572,956,093.16 | 1,086,671,537.27 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 172,983,418.42 | 172,983,418.42 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 311,643,563.78 | 202,071,880.33 | 745,939,511.58 | 1,259,654,955.69 |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---------------|--|-------------------------|-------------------------|-----------------------|---------------|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,134,184,000.00 | 1,939,870,695.19 | 194,313,304.81 | 90.90 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,782,217,400.00 | 1,779,463,600.00 | 2,753,800.00 | 99.85 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,782,217,400.00 | 1,779,463,600.00 | 2,753,800.00 | 99.85 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 155,866,900.00 | 155,865,345.19 | 1,554.81 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 155,866,900.00 | 155,865,345.19 | 1,554.81 | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 196,099,700.00 | 4,541,750.00 | 191,557,950.00 | 2.32 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,747,400.00 | 4,027,400.00 | (280,000.00) | 107.47 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 514,400.00 | 514,350.00 | 50.00 | 99.99 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 191,837,900.00 | | 191,837,900.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,134,184,000.00 | 1,890,705,829.54 | 243,478,170.46 | 88.59 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,134,184,000.00 | 1,890,705,829.54 | 243,478,170.46 | 88.59 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,010,308,400.00 | 1,773,978,329.54 | 236,330,070.46 | 88.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,558,630,800.00 | 1,356,103,609.07 | 202,527,190.93 | 87.01 |
| 210101 | Үндсэн цалин | 933,971,000.00 | 817,049,869.02 | 116,921,130.98 | 87.48 |
| 210102 | Нэмэгдэл | 577,368,000.00 | 476,641,194.10 | 100,726,805.90 | 82.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 17,390,000.00 | (17,390,000.00) | |
| 210104 | Урамшуулал | 47,291,800.00 | 45,022,545.95 | 2,269,254.05 | 95.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 194,828,800.00 | 161,792,093.14 | 33,036,706.86 | 83.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 132,483,600.00 | 109,634,585.40 | 22,849,014.60 | 82.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,586,400.00 | 13,514,426.71 | 2,071,973.29 | 86.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,793,100.00 | 6,930,839.83 | 862,260.17 | 88.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,793,100.00 | 6,317,409.07 | 1,475,690.93 | 81.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,172,600.00 | 25,394,832.13 | 5,777,767.87 | 81.47 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 150,866,900.00 | 150,865,345.19 | 1,554.81 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,016,500.00 | 7,016,404.94 | 95.06 | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 140,350,400.00 | 140,350,336.00 | 64.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | 3,498,604.25 | 1,395.75 | 99.96 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 36,045,400.00 | 35,469,382.14 | 576,017.86 | 98.40 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,747,400.00 | 3,747,400.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 32,298,000.00 | 31,721,982.14 | 576,017.86 | 98.22 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,936,500.00 | 64,747,900.00 | 188,600.00 | 99.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,127,400.00 | 54,938,800.00 | 188,600.00 | 99.66 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,809,100.00 | 9,809,100.00 | - | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 123,875,600.00 | 116,727,500.00 | 7,148,100.00 | 94.23 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 123,875,600.00 | 116,727,500.00 | 7,148,100.00 | 94.23 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 123,875,600.00 | 116,727,500.00 | 7,148,100.00 | 94.23 |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|---|---|--|----------------|--|--|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 193,514,153.72 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 242,679,019.37 | | |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 172,649.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд хандив тусламжаар хүлээн авсан 163,945.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 4,740.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 2.189.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1,773.3 мянган төгрөгийн тээвэр шатахууныг тус тус бусад зардалд бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 19,827.4 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 198 ширхэг 37,154.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны ертөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|-----|---|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|-----|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Санхүүгийн үр дүнгийн тайланд хандив тусламжаар хүлээн авсан 163,945.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн. | 1 | 163,945.9 | | | 1 | 163,945.9 | 1 | 163,945.9 | | |
| 2 | Санхүүгийн үр дүнгийн тайланд 4,740.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 2,189.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1,773.3 мянган төгрөгийн шатахууныг тус тус бусад зардалд тайлагнасан. | 1 | 8,703.1 | | | 1 | 8,703.1 | 1 | 8,703.1 | | |
| | Дүн | 2 | 172,649.1 | | | 2 | 172,649.1 | 2 | 172,649.1 | | |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|-----|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|--------------------------------------|-----|---|---------------------|-----|-----|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | | | |
| 2 | Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 198 ширхэг 37,154.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | | | | | | 1 | 37,154.8 | | | | | | |
| | Дүн | 2 | | | | | | 2 | 37,154.8 | | | | | | |

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 168 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 1 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 21,372.5 мянган төгрөгийн 1 гүйлгээ байна. Мөн таван сая төгрөгөөс дээш үнийн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, бэлтгэн нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг 4 байгууллагын 36,939.8 мянган төгрөгийн гүйлгээ байршуулаагүй байна. | 1 | 58,312.3 | | | | | 1 | 58,312.3 |
| Дүн | 1 | 58,312.3 | | | | | 1 | 58,312.3 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд Нийт 26,819.7 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авахдаа тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн | 1 | 26,819.7 | | | | | 1 | 26,819.7 |
| Дүн | 1 | 26,819.7 | | | | | 1 | 26,819.7 |
| Нийт дүн | 1 | 85,132.0 | | | | | 1 | 85,132.0 |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn